

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ШУА	Шинжлэх ухааны академи
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник-эдийн засгийн үндэслэл
ЗГ	Засгийн газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 04/550
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул Уурхайн Хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Уул Уурхайн Хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга, толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээг төлөвлөгөөнд 99.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Төсвийг үр ашиггүй төлөвлөж, зарцуулсан он удаан жил болсон авлага барагдуулаагүй, ажлын хөлснөөс нийгмийн даатгал суутгаагүй, шилэн дансны мэдээлэл байршуулаагүй зэрэг 74,560.1 мянган төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль эрх зүйн акт, санхүүгийн тайлангийн “хэмжилт, үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үзнэ.

**АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,298,999.00	61,298,999.00
33	АВЛАГА	23,000,000.00	14,000,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	9,000,000.00	-
33500	Бусад авлага	14,000,000.00	14,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	14,000,000.00	14,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	47,298,999.00	47,298,999.00
34600	Урьдчилж гарсан зардал	47,298,999.00	47,298,999.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	487,690,867.67	448,174,108.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	487,690,867.67	448,174,108.71
39200	Биет хөрөнгө	477,501,998.91	440,647,957.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	46,277,726.00	46,277,726.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,322,220.72)	(2,644,441.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,250,000.00	17,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,250,000.00)	(17,250,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	714,947,615.00	714,947,615.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(293,886,146.93)	(327,794,567.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,493,280.00	46,493,280.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,478,477.29)	(42,101,877.25)
39217	Ном	5,470,222.85	5,470,222.85
39300	Биет бус хөрөнгө	10,188,868.76	7,526,151.36
39301	Програм хангамж	45,167,892.00	45,167,892.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(34,979,023.24)	(37,641,740.64)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	557,989,866.67	509,473,107.71
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	557,989,866.67	509,473,107.71
51	Засгийн газрын хувь оролцоо	557,989,866.67	509,473,107.71
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	151,495,662.82	151,495,662.82
51200	Хуримтлагдсан үр дүн	385,090,079.70	336,573,320.74
51210	Өмнөх үеийн үр дүн	447,448,153.92	385,090,079.70
51220	Тайлант үеийн үр дүн	(62,358,074.22)	(48,516,758.96)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,404,124.15	21,404,124.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	557,989,866.67	509,473,107.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	606,577,100.00	590,486,192.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	270,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	270,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	606,307,100.00	590,486,192.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	328,947,100.00	347,167,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	328,947,100.00	347,167,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	277,360,000.00	243,319,092.34
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	277,360,000.00	243,319,092.34
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	668,935,174.22	639,002,951.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	668,935,174.22	639,002,951.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,004,975.22	633,776,807.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,670,289.00	278,170,979.00
210101	Үндсэн цалин	226,670,289.00	216,974,058.00
210102	Нэмэгдэл	-	51,654,521.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,542,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,060,734.86	36,234,787.00
210201	Тэтгэврийн даатгал	27,060,734.86	25,595,194.47
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,167,773.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,019,019.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	495,491.70
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,957,308.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,850,000.00	38,850,000.00
210304	Байрны түрээс	38,850,000.00	38,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,350,000.00	12,126,600.00
210401	Бичиг хэрэг	7,725,000.00	9,167,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,900,000.00	1,625,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,725,000.00	1,334,200.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,300,000.00	-
210702	Дотоод албан томилолт	3,300,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	312,651,990.00	227,677,683.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	312,651,990.00	227,677,683.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,621,961.36	40,216,758.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,810,500.01	700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,811,461.35	39,516,758.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,930,199.00	5,226,143.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	410,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,930,199.00	4,816,143.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,405,690.00	1,325,804.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	524,509.00	3,490,339.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(62,358,074.22)	(48,516,758.96)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(62,358,074.22)	(48,516,758.96)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	619,177,100.00	599,486,192.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	270,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	270,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	618,907,100.00	599,486,192.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	328,947,100.00	347,167,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	328,947,100.00	347,167,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	289,960,000.00	252,319,092.34
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	289,960,000.00	252,319,092.34
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	616,977,100.00	599,486,192.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	616,977,100.00	599,486,192.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	614,046,901.00	594,260,049.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,670,289.00	278,170,979.00
210101	Үндсэн цалин	208,659,589.00	216,974,058.00
210102	Нэмэгдэл	10,693,100.00	51,654,521.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,317,600.00	9,542,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,835,223.00	36,234,787.00
210201	Тэтгэврийн даатгал	26,835,223.00	25,595,194.47
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,167,773.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,019,019.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	495,491.70
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,957,308.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,850,000.00	38,850,000.00
210304	Байрны түрээс	38,850,000.00	38,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,350,000.00	12,126,600.00
210401	Бичиг хэрэг	7,725,000.00	9,167,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,900,000.00	1,625,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,725,000.00	1,334,200.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,300,000.00	-
210702	Дотоод албан томилолт	3,300,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	302,730,889.00	227,677,683.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,730,889.00	227,677,683.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,810,500.00	700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,810,500.00	700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,930,199.00	5,226,143.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	410,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,930,199.00	4,816,143.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,405,690.00	1,325,804.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	524,509.00	3,490,339.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,200,000.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,200,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,200,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,200,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	2,200,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,200,000.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,495,662.82	21,404,124.15	447,448,153.92	620,347,940.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,495,662.82	21,404,124.15	447,448,153.92	620,347,940.89
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	-	(62,358,074.22)	(62,358,074.22)
6	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,495,662.82	21,404,124.15	385,090,079.70	557,989,866.67
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,495,662.82	21,404,124.15	385,090,079.70	557,989,866.67
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
11	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
12	Тайлант үеийн үр дүн	-	-	(48,516,758.96)	(48,516,758.96)
13	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	151,495,662.82	21,404,124.15	336,573,320.74	509,473,107.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	347,167,100.00	345,841,296.00	(1,325,804.00)	99.62
УРСГАЛ ЗАРДАЛ	347,167,100.00	345,841,296.00	(1,325,804.00)	99.62
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,757,100.00	345,431,296.00	(1,325,804.00)	99.62
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,952,800.00	268,864,250.00	(88,550.00)	99.97
Үндсэн цалин	212,729,600.00	207,667,329.00	(5,062,271.00)	97.62
Нэмэгдэл	48,905,600.00	51,654,521.00	2,748,921.00	105.62
Унаа хоолны хөнгөлөлт	7,317,600.00	9,542,400.00	2,224,800.00	130.40
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,308,700.00	35,071,446.00	(1,237,254.00)	96.59
Тэтгэврийн даатгал	25,550,500.00	24,431,853.47	(1,118,646.53)	95.62
Тэтгэмжийн даатгал	2,689,500.00	3,167,773.00	478,273.00	117.78
ҮОМШӨ-ний даатгал	2,151,700.00	2,019,019.00	(132,681.00)	93.83
Ажилгүйдлийн даатгал	537,900.00	495,491.70	(42,408.30)	92.12
Эрүүл мэндийн даатгал	5,379,100.00	4,957,308.83	(421,791.17)	92.16
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,850,000.00	38,850,000.00	-	100.00
Байрны түрээс	38,850,000.00	38,850,000.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	1,445,600.00	1,445,600.00	-	100.00
Бичиг хэрэг	111,400.00	111,400.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,334,200.00	1,334,200.00	-	100.00
Нормативт зардал	500,000.00	500,000.00	-	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	410,000.00	410,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	410,000.00	410,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	347,167,100.00	345,841,296.00	(1,325,804.00)	99.62
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	347,167,100.00	345,841,296.00	(1,325,804.00)	99.62
Улсын төсвөөс санхүүжих	347,167,100.00	345,841,296.00	(1,325,804.00)	99.62
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	41.00	41.00	-	100.00

БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20.00	20.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		252,319,092.34
УРСГАЛ ЗАРДАЛ		252,319,092.34
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		248,828,753.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,306,729.00
Үндсэн цалин		9,306,729.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,163,341.00
Тэтгэврийн даатгал		1,163,341.00
Хангамж, бараа материалын зардал		10,681,000.00
Бичиг хэрэг		9,056,000.00
Тээвэр, шатахуун		1,625,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		227,677,683.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		227,677,683.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,490,339.34
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,490,339.34
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3,490,339.34
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		252,319,092.34
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		252,319,092.34

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Уул уурхайн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Х.Жаргалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, бараа материал, авлага, цалин, урьдчилж гарсан зардлын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Уваа уул аудит” ХХК-ын ахлах аудитор Ц.Мөнхтуяа, аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Уул уурхайн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа Уул Аудит” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Уул уурхайн хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Удирдлага зохион байгуулалтын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацыг хөгжүүлэх”-д оршино.

Уул уурхайн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсад уул уурхайн салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх;
- Олон улсын түвшинд хүрсэн эко бүтээгдэхүүн үйлдвэрлэх судалгаа явуулах;
- Эрдэм шинжилгээ
- ТЭЗҮ, зураг төсөл
- Лаборатори, хагас үйлдвэрлэлийн туршилт

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын хууль:

- Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 78, 114 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол:

- 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай”
- 2020 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Уул уурхайн хүрээлэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 252,920.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,529.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 639,002.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,390.0 мянган төгрөгөөр өөрчлөн тогтоов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Уул уурхайн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,516.8 мянган төгрөгөөр буюу 8.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Засгийн газрын оролцоо, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	23,000.0	14,000.0	(9,000.0)
Урьдчилгаа	47,299.0	47,299.0	0.0
Үндсэн хөрөнгө	487,690.9	448,174.1	(39,516.8)
Нийт хөрөнгө	557,989.9	509,473.1	(48,516.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	557,989.9	509,473.1	(48,516.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	557,989.9	509,473.1	(48,516.8)

Авлага дансны үлдэгдэл 14,000.0 мянган төгрөг болж, 9,000.0 мянган төгрөгөөр буурсан нь гэрээт ажлын хөлс барагдсанаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн Амгуулин ХХК-аас авах 14,000.0 мянган төгрөгийн он удаан жил болсон эрсдэлтэй авлага байна.

Урьдчилгаа дансны 47,299.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь 2017-2019 онд хэрэгжиж дууссан төслийн ажлыг захиалагч хүлээн аваагүйтэй холбоотой байна. Энэ нь тайлант онд гарсан зардлаа хүлээн зөвшөөрч, үйл ажиллагааны үр дүн үнэн зөв илэрхийлэгдэхгүйд хүргэж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 448,174.1 мянган төгрөг болж, 39,516.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдэлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 509,473.1 мянган төгрөг болж, 48,516.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Уул уурхайн хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16,090.9 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 29,932.2 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал байна. Энэ нь ТЭЗҮ хийх ажил багассантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 347,167.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 347,167.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулаагүй, 347,167.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр 347,167.1 мянган төгрөгийн улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 347,167.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 345,841.3 мянган төгрөгийг зарцуулж, 1,325.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 345,841.3 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 88.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1,237.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 1,325.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 243,319.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 227,677.7 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 9,306.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 1,163.3 мянга, бичиг хэргийн зардалд 9,056.0 мянга, тээвэр, шатахууны зардалд 1,625.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3,490.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 174 мэдээллээс хугацаандаа оруулсан 154 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээлэл, 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналтай тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын 4 удаагийн 70,337.1 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй;
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 10 удаагийн 214,689.1 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаалыг байршуулаагүй;

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй, УАГ-ийн түүвэрт хамрагдсан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 289,249.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,360.8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 269,331.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 18,556.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа залруулаагүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 270,692.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,360.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 269,331.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тус хүрээлэнгийн захирал өөртөө тушаал гарган зөвлөхийн нэмэгдэл гэж 1,360.8 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тус хүрээлэн нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 227,677.7 мянган төгрөгийн нэмэлт орлогоос ажлын хөлс олгохдоо ажил олгогчоос төлөх 28,459.7 мянган төгрөг, даатгуулагчаас төлөх 26,182.9 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-д “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна” гэсэн заалттай нийцэхгүй үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Шилэн дансанд 10 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, 10 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын үнийн дүн бүхий 4 удаагийн 70,337.1 мянга, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 10 удаагийн 214,689.1 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг огт байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 18,556.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материал данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус хүрээлэн нь Бараа материалын эхний, эцсийн үлдэгдэлгүй байгааг тулган шалгахад 2,391.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг худалдан аваад шууд зардлаар гаргасан байна.

1.2. Эрсдэл:

Бараа материал дансны үлдэгдэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгө шамшигдах,

1.3. Өгсөн зөвлөмж:

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 249 тоот “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” -ын 4.21.г заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангаж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч В501 маягтаар баталгаажуулсан.

2. Авлага данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

“Амгуулин” ХХК-аас авах 2016 онд үүссэн 14,000.0 мянган төгрөгийн он удаан жил болсон эрсдэлтэй авлага байна.

2.2. Эрсдэл:

Энэ нь байгууллагын санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлөх,

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангаж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч В501 маягтаар баталгаажуулсан.

3. Цалингийн зардалтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Хүрээлэнгийн захирал нь Засгийн газрын 2019 оны 472 болон 276 дугаар тогтоолын дагуу ТҮШУ-5 зэрэглэлээр 1,038,6 мянган төгрөгийн цалин авах байтал Шинжлэх Ухааны Технологийн Их Сургуулийн Захирлын 2018 оны А/197 дугаар

тушаалаар үндсэн цалинг 1,536.5 мянган төгрөг болгож 2,165.7 мянган төгрөгийн цалин илүү авсан.

3.2. Эрсдэл:

Цалинг Засгийн газраас тогтоон цалингийн сүлжээний дагуу олгоогүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Засгийн Газрын 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, 472 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”-ын дагуу үндсэн цалинг тогтоож олгох.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч В501 маягтаар баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.2.25	Аудитын нэр: Уул уурхайн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/94/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Уул Уурхайн Хүрээлэн	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Тус хүрээлэнгийн захирал өөртөө тушаал гарган зөвлөхийн нэмэгдэл гэж 1,360.8 мянган төгрөгийн цалинг илүү олгосонн.	1,360.8	Төлбөрийн акт	Захирал Нягтлан бодогч	Х.Жаргалсайхан М.Дөлгөөн
2	Тус хүрээлэн нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 227,677.7 мянган төгрөгийн нэмэлт орлогоос ажлын хөлс олгохдоо ажил олгогчоос төлөх 28,459.7 мянган төгрөг, даатгуулагчаас төлөх 26,182.9 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй.	54,642.6	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Х.Жаргалсайхан М.Дөлгөөн
3	Шилэн дансанд 10 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, 10 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 13 удаагийн 330,693.7 мянга, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 10 удаагийн 214,689.1 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг огт байршуулаагүй.	214,689.1	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Х.Жаргалсайхан М.Дөлгөөн
4	"Амгуулин" ХХК-аас авах 2016 онд үүссэн 14,000.0 мянган төгрөгийн он удаан жил болсон эрсдэлтэй авлага байна.	14,000.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Х.Жаргалсайхан М.Дөлгөөн
5	Хүрээлэнгийн захирал нь Засгийн газрын 2019 оны 472 болон 276 дугаар тогтоолын дагуу ТҮШУ-5 зэрэглэлээр 1,038,6 мянган төгрөгийн цалин авах байтал Шинжлэх Ухааны Технологийн Их Сургуулийн Захирлын 2018 оны А/197 дугаар тушаалыг үндэслэн 1,536.5 мянган төгрөгийн үндсэн цалин авч байна. /Тайлант онд 2,165.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон/	2,165.7	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Х.Жаргалсайхан М.Дөлгөөн

6	Тус хүрээлэн нь Бараа материалын эхний, эцсийн үлдэгдэлгүй байгааг тулган шалгахад 2,391,4 мянган төгрөгийн хангамжийн материалыг худалдан аваад шууд зардлаар гаргасан байна.	2,391.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Х.Жаргалсайхан М.Дөлгөөн
ДҮН		289,249.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 43/АД160058

Улаанбаатар хот

САГ-2021/04/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул Уурхайн Хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хүрээлэнгийн захирал эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө тушаал шийдвэр гарган зөвлөх инженерийн нэмэгдэл 1,360,800.00 (нэг сая гурван зуун жаран мянга найман зуун) төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон 1,360,800 (нэг сая гурван зуун жаран мянга найман зуун) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул Уурхайн Хүрээлэнгийн захирал Х.Жаргалсайхан, нягтлан бодогч М.Дөлгөөн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
"УВАА УУЛ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Akt\2021\0225auditin 2-R Газар39.Docx

001090498



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 159/A0160058

Улаанбаатар хот

САГ-2021/94/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхайн Хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих нийт 174 мэдээллээс 10 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, 10 мэдээллийг байршуулаагүй, мөн цалингийн зардлаас бусад 5.00 сая төгрөгийн орлого, зарлагын 4 удаагийн 70,337,100.00 (далан сая гурван зуун гучин долоон мянга нэг зуун) төгрөг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 10 удаагийн 214,689,100.00 (хоёр зуун арван дөрвөн сая зургаан зуун наян есөн мянга нэг зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уул Уурхайн Хүрээлэнгийн захирал Х.Жаргалсайхан, нягтлан бодогч М.Дөлгөөн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
"УВАА УУЛ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 152/АД/160058

Улаанбаатар хот

САГ-2021/94/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхайн Хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хүрээлэн нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 227,677,700 (хоёр зуун хорин долоон сая зургаан зуун далан долоон мянга долоон зуун) төгрөгийн нэмэлт орлогоос нэр бүхий 37 ажилтанд ажлын хөлс олгохдоо ажил олгогчоос төлөх 28,459,700.00 (хорин найман сая дөрвөн зуун тавин есөн мянга долоон зуун) төгрөг, даатгуулагчаас төлөх 26,182,900.00 (хорин зургаан сая нэг зуун наян хоёр мянга есөн зуун) төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тус тус суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-д "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, дээрх зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уул Уурхайн Хүрээлэнгийн захирал Х.Жаргалсайхан, нягтлан бодогч М.Дөлгөөн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

"УВАА УУЛ АУДИТ" ХК-ИЙН ЗАХИРАЛ,
АУДИТОР

Ч.МӨНХТУЯА

